

**ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН МАТЕРИАЛ
2025**

УЛААНСАН ХК

АГУУЛГА

| | |
|---|----|
| ХУРЛЫН ЗАР _____ | 3 |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ _____ | 3 |
| ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ _____ | 5 |
| ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ _____ | 6 |
| КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА _____ | 7 |
| Ногдол ашиг _____ | 7 |
| Санхүүгийн тайлан _____ | 7 |
| ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ _____ | 9 |
| ХАВСРАЛТ 1. ДҮРМИЙН ТӨСӨЛ _____ | 11 |
| ХАВСРАЛТ 2. САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР _____ | 22 |
| ХАВСРАЛТ 3. ТОГТООЛЫН ТӨСӨЛ _____ | 24 |

ХУРЛЫН ЗАР

"УЛААНСАН" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Улаансан” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 сарын 10-ны өдрийн тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлаж байна.

ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ГАЗАР: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай - 2, Сентрал Тауэр 17 давхарт

ХУГАЦАА: 2025 оны 04 сарын 21-ний өдрийн 15:00 цагт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ОНООСОН НЭР: “УЛААНСАН” ХК

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;
2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх;
3. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах;
4. Компанийн дүрмийг шинэчлэн батлах;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг чөлөөлөх;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох;

БҮРТГЭЛИЙН ӨДӨР: 2025 оны 04 сарын 02-ны өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл, хавсралт;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал;

Хувьцаа эзэмшигч та ажлын өдрүүдэд 9:00–18:00 цагийн хооронд доорх газруудад хандаж хурлын материал, саналын хуудастай танилцах боломжтой.

- Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Чингисийн талбай-2, Сентрал Тауэр, 1 давхар;
- Имэйл хаяг: info@ardsecurities.com
- Утас: 88206400, 77003322,

Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол “Ард Секюритиз” ҮЦК ХХК-д очиж саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал тауэр, 17 давхар хаягаар “Улаансан” ХК-д шуудангаар явуулах боломжтой. Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 04 сарын 18-ны өдрийн 16:00 цаг байна.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

“УЛААНСАН” ХК

2025 оны 03 сарын 10

№25/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Компанийн дүрмийн 8.2, 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **“Улаансан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:**

1. “Улаансан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (шашид “Хурал” гэх)-ыг **2025 оны 04 сарын 21-ний өдрийн 15:00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай - 2, Централ Тауэр 17 давхарт** хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 02-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 03 сарын 13-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан 2025 оны 03 сарын 14-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2025 оны 03 сарын 28-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулсугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2025 оны 03 сарын 19-ний өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2025 оны 04 сарын 18-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.
8. Хурлын даргаар Өнөрбаян овогтой Ашхүүг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:
Ө.Ашхүү
Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
С.Дэлгэржаргал

1

“УЛААНСАН” ХК

Б.Оюунсүвд

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга:
Ө. Бямбагэрэл, Хуулийн зөвлөх
Тооллогын комиссын гишүүд:
Ч.Даваанзэрэн, Санхүүгийн шинжээч,
А.Эрхбилгүүн, Хөрөнгө оруулалтын зөвлөх
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

(Хурал 2025 оны 04 сарын 21-ний өдрийн 15:00 цагт эхэлж 17:00 цагт дуусах)

| № | Хуваарь | Хариуцах тал | Цаг |
|---|---|------------------|-------------|
| 1 | Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/; | Тооллогын | 15:00-15:15 |
| 2 | Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/; | комисс | |
| 3 | Хурлын дарга хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах; | Хурлын дарга | 15:15-15:35 |
| 4 | Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах; | Хурлын дарга | 15:35-16:10 |
| 5 | Хэлэлцэх асуудал тус бүрээр санал хураалт | Тооллогын комисс | 16:10-16:25 |
| 6 | Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах; | Тооллогын комисс | 16:25-16:35 |
| 7 | Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах; | Хурлын дарга | 16:35-16:55 |
| 8 | Хурлыг хаах | | 17:00 |

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;
2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх;
3. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах;
4. Компанийн дүрмийг шинэчлэн батлах;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг чөлөөлөх;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох;

--o0o--

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

| | |
|--|--|
| Компанийн нэр | Улаансан ХК |
| Компанийн хэлбэр | Нээлттэй хувьцаат компани |
| Хуулийн этгээдийн улсын бүртгэл | УБД: 1510001013 РД: 2002116 |
| Үйл ажиллагааны чиглэл | <ul style="list-style-type: none"> Газар тариалан Таван хошуу мал аж ахуй Гахайн аж ахуй Гадаад, дотоод худалдаа үйлчилгээ Малын хадлан тэжээл бэлтгэх Гурил хийх Техник засвар үйлчилгээ |
| Санхүүгийн үзүүлэлт /2023 оны 4 улириал/ | Хөрөнгө: 19,667 мян.төгрөг Эздийн өмч: 227,362 мян.төгрөг Өр төлбөр: 0 |
| Гүйцэтгэх захирал | Ө.Ашхүү |
| Ажилчдын тоо | 0 |
| Хаяг | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхар |

“Улаансан” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид 1993 оны 07 сарын 01-ний өдөр бүртгүүлсэн нээлттэй хувьцаат компани юм. Компани нь 2007 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй. Компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчид өөрчлөгдсөн ба 2024 оноос компанийн хувьцааны арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сэргээн явуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Ногдол ашиг

Улаансан ХК нь 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй тул 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №25/01 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Санхүүгийн тайлан

Санхүү байдлын тайлан /төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2023 Q4 | 2024 Q4 |
|----------------------------------|-------------------|-------------------|
| Хөрөнгө | | |
| Эргэлтийн хөрөнгө | 24,500 | 24,500 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 24,500 | 24,500 |
| Татвар, НДШ-ийн авлага | 0 | 0 |
| Бусад авлага | 0 | 0 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 0 | 0 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 19,667,300 | 19,667,300 |
| Нийт хөрөнгийн дүн | 19,691,800 | 19,691,800 |
| Өр төлбөр ба эздийн өмч | | |
| Богино хугацаат өр төлбөр | | |
| Дансны өглөг | 0 | 0 |
| Татварын өр | 0 | 0 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 0 | 0 |
| Урт хугацаат өр төлбөр | 0 | 0 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 0 | 0 |

| | | |
|--|-------------------|-------------------|
| Өр төлбөрийн нийт дүн | 0 | 0 |
| Эздийн өмч | | |
| Хувьцаат өмч | 5,595,200 | 5,595,200 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 227,362,600 | 227,362,600 |
| Хуримтлагдсан алдагдал | -213,266,000 | -213,266,000 |
| Эздийн өмчийн дүн | 19,691,800 | 19,691,800 |
| Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн | 19,691,800 | 19,691,800 |

Орлогын тайлан /төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2023 Q4 | 2024 Q4 |
|---|----------------|----------------|
| Борлуулалтын орлого | 7,320,100 | 0 |
| Хүүний орлого | 0 | 0 |
| Нийт ашиг | 0 | 0 |
| Түрээсийн орлого | 0 | 0 |
| Ногдол ашгийн орлого | 0 | 0 |
| Эрхийн шимтгэлийн орлого | 7,320,100 | 0 |
| Бусад орлого | 0 | 0 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 0 | 0 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 7,320,100 | 0 |
| Санхүүгийн зардал | 0 | 0 |
| Бусад зардал /ҮАБЗ/ | 0 | 0 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0 | 0 |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | 0 | 0 |
| Бусад ашиг (алдагдал) | 0 | 0 |
| Нийт | 0 | 0 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 0 | 0 |
| Орлогын татварын зардал | 0 | 0 |
| Татварын дараахь ашиг (алдагдал) | 0 | 0 |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | 0 | 0 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0 | 0 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 0 |
| Орлогын нийт дүн | 0 | 0 |

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Компанийн жилийн үйл ажиллагааг зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах:

Компани нь 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй. Харин Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр сонгох, хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх, засаглалын дүрэм журмуудыг шинэчлэн батлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн, үйл ажиллагааг сэргээн явуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллаа.

Санхүүгийн байдлын хувьд Компани нь жилийн эцсийн байдлаар 19,667 мян.төгрөгийн нийт хөрөнгөтэй, хуримтлагдсан алдагдал 213,266 мян.төгрөг тус тус байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул орлого олоогүй.

2. Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах:

Компанийн жилийн санхүүгийн тайланд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “ЦЭСБ Аудит” ХХК аудит хийсэн. Аудитын зүгээс Компани нь “2024 оны 12 сарын 31-н өдрийн байдлаар санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулж байна” гэж дүгнэсэн.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрч, дүгнэсэн болно.

3. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах:

Компанийн үйл ажиллагааны чиглэлийг цаашид эрхлэх үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулах хүрээнд дараах өөрчлөлтийг оруулахаар санал оруулж байна:

| Одоогийн үйл ажиллагааны чиглэл | Өөрчлөгдөх үйл ажиллагааны чиглэл |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> Газар тариалан Таван хошуу мал аж ахуй Гахайн аж ахуй Гадаад, дотоод худалдаа үйлчилгээ Малын хадлан тэжээл бэлтгэх Гурил хийх Техник засвар үйлчилгээ | <ul style="list-style-type: none"> Менежментийн зөвлөгөө өгөх |

4. Компанийн дүрмийг шинэчлэн батлах:

Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор Компанийн дүрмийг шинэчлэн батлуулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулсан.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хугацаанаас өмнө чөлөөлөх:

Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгохоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал оруулж байгаа болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг дуусгавар болгох гишүүдийн нэрс:

| 1 | ТУЗ ийн дарга | Чулууны Ганхуяг |
|---|---------------------------|-------------------------|
| 2 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Галням Уянга |
| 3 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Хүрэлбаатарын Билгүүн |
| 4 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Сүхчулууны Нямгэрэл |
| 5 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Батбилэгийн Золбоо |
| 6 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Чадраабалын Даваасамбуу |
| 7 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Гандоржийн Зол-Эрдэнэ |
| 8 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Цогбадрахын Батбаяр |

| | | |
|---|---------------------------|----------------------|
| 9 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Алтангэрэлийн Азбаяр |
|---|---------------------------|----------------------|

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд шинээр сонгохоор нэр дэвшүүлж байгаа нэр дэвшигчдийн мэдээллийг доор оруулав.

Ердийн гишүүнээр нэр дэвшигчид:

| | | |
|---|-----------------------|-----------------|
| 1 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Ч.Ганхуяг |
| 2 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Г.Уянга |
| 3 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Б.Золбоо |
| 4 | ТУЗ-ийн ердийн гишүүн | П.Батбаяр |
| 5 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Михаил Зелдович |
| 6 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Ц.Тайшир |
| 7 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Ч.Даваасамбуу |
| 8 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Х.Билгүүн |

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид:

| | | |
|---|---------------------------|-----------------|
| 1 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Г.Зол-Эрдэнэ |
| 2 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | А.Азбаяр |
| 3 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Б.Бямбасайхан |
| 4 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Б.Баатармөнх |
| 5 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Стивен Ру |
| 6 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Э.Амарбаясгалан |

ХАВСРАЛТ 1. ДҮРМИЙН ТӨСӨЛ

“Улаансан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
2025 оны 04 сарын 21-ний өдрийн тоот тогтоолын Хавсралт

“УЛААНСАН” ХК КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Улаансан” ХК нь (цаашид **“Компани”** гэх) Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, Банкны харилцах данстай, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, тусгайлан эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх эдэлж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг, шүүх, арбитрын өмнө өөрийн нэрийн өмнөөс оролцдог хуулийн этгээд байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагддаг нээлттэй хувьцаат компани байна.
- 1.2. Компани нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Компани нь дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээ, компанийн сайн засаглал дэмжих, хүний нөөцийн хөгжил тогтвортой байдлыг хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг өөрөө эсхүл өөрийн салбар, охин компаниудаараа дамжуулан гүйцэтгэж болно.
- 1.4. **Компанийн оноосон нэр:**
а/ Бүтэн нэр **“Улаансан” ХК**
б/ Англиар: **“Ulaansan” Joint Stock Company**
- 1.5. Компанийн оршин байгаа хаяг: **Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхар.**
- 1.6. Компани нь хугацаагүй үйл ажиллагаа явуулна.

ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 2.1. Компани нь дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - 2.1.1. **Менежментийн зөвлөгөө өгөх;**
- 2.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан бизнесийн болон бусад үйл ажиллагаа эрхлэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 2.3. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүдийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 2.4. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагаа Иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдана.
- 2.5. Компани нь үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулж, хувьцаа эзэмшигчдийг компанийн үйл ажиллагааны мэдээллээр тогтмол хангана.

ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 3.1. Компанийн энгийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

- 3.2. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:
- 3.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 3.2.2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
 - 3.2.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
 - 3.2.4. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжид худалдан авах;
 - 3.2.5. Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:
 - 3.2.5.1. Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах болсон бол;
 - 3.2.5.2. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;
 - 3.2.5.3. компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
 - 3.2.5.4. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
 - 3.2.6. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
 - 3.2.7. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.
 - 3.2.8. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.
- 3.3. Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:
- 3.3.1. хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
 - 3.3.2. нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;
 - 3.3.3. нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх;
- 3.4. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.
- 3.5. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА БУСАД ҮНЭТ ЦААС ТҮҮНИЙГ ГАРГАХ, ХУДАЛДАХ БОЛОН ЭРГҮҮЛЭН АВАХ

- 4.1. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.
- 4.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 124,354,000 төгрөг, **62,177 ширхэг хувьцаа, балансын дүнгээр нэрлэсэн үнэ 2,000 төгрөг** байна.
- 4.3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 2000 (хоёр мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 62,177 ширхэг энгийн зарласан хувьцаатай байна.
- 4.4. Компани нь энгийн болон давуу эрхийн хувьцааг шинээр нэмж гаргаж болно.
- 4.5. Хуульд өөрөөр заагаагүй бол компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшлийн хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй.
- 4.6. Компанийн хувьцаа эзэмшигч нь дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө.
- 4.7. Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, бүртгэлийг хөтлүүлнэ.
- 4.8. Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно:
 - 4.8.1. Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;
 - 4.8.2. Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох;
 - 4.8.3. Өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх.
- 4.9. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу энгийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.
- 4.10. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо нэрлэсэн үнэ, үнийн дүн, гаргах хугацаа нөхцөл зэргийг заасан байна.
- 4.11. Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ бизнес эрхлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 4.12. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ шийдвэрлэнэ.
- 4.13. Хувьцаа бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 4.14. Компаниас шинээр гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлбэрээр хийхийг сонирхогч бус ТУЗ-ийн саналаар тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын санал дүгнэлтийг үндэслэл болгоно.
- 4.15. ТУЗ-ийн шийдвэрээр компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.
- 4.16. Компани нь дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж болно.
 - 4.16.1. хуульд заасан үүргийнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;
 - 4.16.2. үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;
 - 4.16.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их бол.

- 4.17. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 5.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх) байна.
- 5.2 ХЭХ нь ээлжит ба ээлжит бус байна.
- 5.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор ТУЗ-өөс зарлаж хуралдуулах бөгөөд Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргаж хуралдуулна.
- 5.4 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулна.
- 5.5 ХЭХ-р энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 5.6 Энэхүү дүрмийн 5.3 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шийдвэрт тусгагдсан хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ХЭХ-ыг даргалах боломжгүй болсон тохиолдолд Компанийн ТУЗ-ийн дарга нь ХЭХ-ыгудирдана.
- 5.7 ХЭХ-д нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход Компанийн тухай хуулийн 71.5, 72.1.3, 72.2, 77.1-г тус тус заасны дагуу санал хураалтын кумулятив аргаар явуулна.
- 5.8 Компанийн тухай хуульд зааснаар дийлэнх олонхоор, эсхүл кумулятив аргаар шийдэх асуудлаас бусад тохиолдолд ХЭХ-р хэлэлцсэн асуудлыг ердийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 5.9 Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна.
- 5.10 Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлд заасан журмын дагуу ХЭХ-д өөрийн биеэр буюу бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.
- 5.11 Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг ХЭХ-д оролцсон гэж үзнэ. Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байна.
- 5.12 Компанийн саналын эрхтэй хувьцааны энгийн олонх хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуулах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаас хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй болно.
- 5.13 Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5-д заасан журмын дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.
- 5.14 ХЭХ-р шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.
- 5.15 Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3-г заасан асуудлыг тусгасан байна.
- 5.16 Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө ХЭХ-ын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.
- 5.17 ХЭХ-ын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, ХЭХ-ын дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 6.1 ХЭХ-ын чөлөө цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэ дүрмээр хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 6.1.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 6.1.2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;
- 6.1.3. ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 6.1.4. Хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй охин, хараат компаниудын хуьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- 6.1.5. Компанийн тухай хууль болон хувь нийлүүлэгчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.
- 6.2 Компанийн ТУЗ нь 9-өөс доошгүй гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувь нийлүүлэгч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.
- 6.3 ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хэдэн удаа ч хурал зарлан хуралдуулж болно.
- 6.4 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн санал хураалтын олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн үүрэг гүйцэтгэнэ.
- 6.5 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих үүргийг хүлээнэ.
- 6.6 ТУЗ-өөс гаргасан тогтоол нь ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, Компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.7 ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн дотоод журмаар тогтооно. ТУЗ нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.
- 6.8 ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор хороодтой байна. Эдгээр хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 6.9 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, Компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 6.10 ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 6.11 ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу ТУЗ-р сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.
- 6.12 ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 6.13 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд ТУЗ-ийн Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажлын туршлага, мэргэжлийн ур чадварыг үндэслэн холбогдох шийдвэр, зөвлөмжийг гаргана.
- 6.14 ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
- 6.14.1. Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;

- 6.14.2. ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байна;
- 6.14.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх;
- 6.14.4. өрсөлдөгч Компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх;
- 6.14.5. ТУЗ-ийн хуралд идэвхтэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог дайчлах, ХЭХ-д ажлаа тайлагнах үүрэгтэй.
- 6.15. Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор (i) Аудитын хороо, (ii) Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, (iii) Санхүү, эрсдэл, зээлийн хороог тус тус байгуулан ажиллуулна.
- 6.16. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
 - 6.16.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
 - 6.16.2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, ТУЗ-д танилцуулах;
 - 6.16.3. Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
 - 6.16.4. Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх (чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ);
 - 6.16.5. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
 - 6.16.6. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 6.17. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 6.17.1. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
 - 6.17.2. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 6.17.3. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх;
 - 6.17.4. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 6.17.5. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
 - 6.17.6. ТУЗ-ийн гишүүдээс бусад Компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
 - 6.17.7. Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат Компанийн ТУЗ-ийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс тагталзах;
 - 6.17.8. Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
 - 6.17.9. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
 - 6.17.10. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

- 6.17.11. Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон Компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
- 6.17.12. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
- 6.18 Санхүү, эрсдэл, зээлийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.18.1. Компанийн стратеги төлөвлөгөөг судалгааны үндсэн дээр боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах;
 - 6.18.2. Санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтөд нийцсэн эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, шинээр хийгдэх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд стратегийн эрсдэлийн урьдчилан дүгнэлт гаргах, чиглэл, зөвлөмж боловсруулах;
 - 6.18.3. Компанийн үнэ цэнийг тодорхойлж, хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах;
 - 6.18.4. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж стратегийн удирдамж чиглэлээр хангаж ажиллах ба дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, томоохон гэрээ хэлцлүүд, Компанийн өөрчлөн байгуулалт (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах г.м) зэрэгт хяналт тавьж ажиллана;
 - 6.18.5. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 6.19. ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн Компанийн холбогдох үйл ажиллагаа, ХЭХ-д оролцоогүй, идэвх хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй.
- 6.20. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасны дагуу ТУЗ-ын даргын санал болгосноор ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгана.
- 6.21. ТУЗ нь жилд нэгээс доошгүй удаа ХЭХ-д ажлаа тайлагнана.
- 6.22. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй байна. Үүнд:
 - 6.22.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, Компанийн дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцэж байгаа эсэх, Компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил гаргасан бол зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, ХЭХ-ыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;
 - 6.22.2. Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
 - 6.22.3. ХЭХ-д биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах;
 - 6.22.4. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

ДОЛОО. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 7.1. Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

- 7.2. Гүйцэтгэх удирдлагын ТУЗ-тэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 7.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 7.4. Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ ТУЗ-д хуанлийн нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 7.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд Компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх зэргээр Компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 7.6. Гүйцэтгэх захирлыг томилох, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-өөс гүйцэтгэх захирлыг чөлөөлсөн тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд захирлыг үүргийг түр орлон гүйцэтгэнэ.
- 7.7. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно. Энэхүү саналыг гаргахдаа хэлэлцүүлэх асуудлын талаарх танилцуулга, гарах шийдвэрийн төсөл зэргийг хүргүүлнэ.
- 7.8. ТУЗ нь холбогдох хууль тогтоомж болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд заасан үндэслэлээр Гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх, өөрчлөх эрх хэмжээг хэрэгжүүлнэ.

НАЙМ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

- 8.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирлууд, хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд, хараат болон охин Компаниудын захирлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг Компанийн албан ёсны шийдвэрийг гаргах, гэрээ хэлцэл байгуулахад оролцдог ажилтнуудыг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 8.2. нь Компанийн дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах ба Компанийн ажил үүргийг гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авахыг хориглоно.
- 8.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас Компанид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.
- 8.4. Үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар явуулж, Компанийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажиллана.
- 8.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-т заасан үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.6. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь ТУЗ-ийн өмнө Компанийн үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээнэ. Холбогдох хууль тогтоомж, энэ дүрэмд заасныг зөрчиж шийдвэр гаргасан албан тушаалтнууд хамтын хариуцлага хүлээх бөгөөд хохирлыг тэнцүү хэмжээгээр нөхөн төлнө.
- 8.7. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдагч этгээдэд задруулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх үүрэгтэй.
- 8.8. Компанитай байгуулсан гэрээгээр илүү урт хугацаа тогтоогоогүй бол албан тушаал өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 84.4.6-д заасан үүргийг хүлээнэ.
- 8.9. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн

төлөхөөс гадна энэ шалтгаанаар Компанид торгуулийн арга хэмжээ ногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

ЕС. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

- 9.1. Компанийн дүрэм, ХЭХ-ын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, Компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- 9.2. ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар аудитын хороо нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатай сонгогдоно.
- 9.3. Компанийн аудитын хорооны бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдэд тавих шаардлага зэргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулах бөгөөд бусад зүйлсийг аудитын хорооноос баталсан дотоод журмаар зохицуулна.
- 9.4. Аудитын хороо нь Компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэхүү дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.
- 9.5. Аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.
- 9.6. Компани нь жил бүр санхүүгийн үйл ажиллагаандаа хөндлөнгийн шалгалт хийлгэж, тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар заавал аудит хийж гүйцэтгүүлэх бөгөөд тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.
- 9.7. Аудитын хороо нь Аудитын тухай хуульд заасны дагуу Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг ТУЗ-өөр батлуулна.
- 9.8. Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд Компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудитор төлөх хөлсний хэмжээг заана.
- 9.9. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудитын байгууллагын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.
- 9.10. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 9.11. Дараах этгээдийг Компанийн дотоод аудитор болон аудитын байгууллагаар сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
 - 9.11.9. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, Компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрт нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой Компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
 - 9.11.10. Компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эзэмшдэг бол;
 - 9.11.11. Компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол;
- 9.12. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан Компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.

АРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

- 10.1. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтлөн санхүүгийн тайлан гаргаж татварын байгууллага болон бусад хуульд заасан байгууллагад хугацаанд нь хүргүүлнэ.
- 10.2. Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацааг тухайн оны 01 сарын 01-нээс, дуусах хугацааг мөн оны 12 сарын 31-ний өдрөөр тогтооно.

- 10.3. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг Компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.
- 10.4. Санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:
 - 10.4.1. Санхүүгийн байдлын тайлан
 - 10.4.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан
 - 10.4.3. Мөнгөн гүйлгээний тайлан
 - 10.4.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан
 - 10.4.5. Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт
 - 10.4.6. Нэмэлт тайлбар тодруулга
 - 10.4.7. Санхүүгийн тайлангийн тодруулга
 - 10.4.8. Бусад.
- 10.5. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ-ийн тогтоолд хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах “бүртгэлийн өдөр” болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 10.6. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:
 - 10.6.1. ногдол ашиг төлсний дараа Компани төлбөрийн чадвартай байх;
 - 10.6.2. ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 10.6.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 10.7. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн Компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.
- 10.8. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг ХЭХ-д тайлагнана.

АРВАН НЭГ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

- 11.1 Компанийг ХЭХ-ын шийдвэрээр буюу Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр өөрчлөн байгуулах (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн зохион байгуулах замаар) өөрчлөн байгуулж болно.
- 11.2 Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 11.3 Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана. Компанийг татан буулгах үед хуульд заасан өр төлбөрийг нь барагдуулах, хувьцаа эзэмшигчдэд эд хөрөнгийг нь хуваарилах ба бусад асуудлыг шийдвэрлэнэ.
- 11.4 Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.
- 11.5 Бүртгэх байгууллага Компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

АРВАН ХОЁР. БУСАД

- 12.1 Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 12.2 Энэхүү дүрэм болон холбогдох журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

12.3 Энэхүү дүрэм нь холбогдох бүртгэлийн газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж Компани татан буугдах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл үйлчилнэ.

--ooOoo--

ХАВСРАЛТ 2. САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 03 сарын 10-ны өдрийн
25/03 тоот тогтоолын Хавсралт 3

“УЛААНСАН” ХК САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар **2025 оны 04 сарын 21-ний өдрийн 15:00 цагт** хуралдах “Улаансан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн **ээлжит бус хуралд** санал өгнө.

| Д/д | Хэлэлцэх асуудлын нэр | Хурлаас гарах шийдвэрийн төсөл | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | Татгалзсан тохиолдолд таны өгөх санал |
|-----|--|--|------------|------------|------------|---------------------------------------|
| 1 | Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт | Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай | | | | |
| 2 | Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх | Хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай | | | | |
| 3 | Эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах | Эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах тухай | | | | |
| 4 | Компанийн дүрмийг шинэчлэн батлах | Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай | | | | |
| 5 | Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг чөлөөлөх; | Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг чөлөөлөх тухай | | | | |

| | | | |
|---|--|--|---|
| 6 | Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох | | Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/ |
| | 1 | | |
| | 2 | | |
| | 3 | | |
| | 4 | | |
| | 5 | | |
| | 6 | | |
| | Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох | | Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/ |
| | 1 | | |
| | 2 | | |
| | 3 | | |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Ард Секюритиз Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч та кумулятив аргаар саналаа өгөхдөө доорх зааварчилгааг анхааралтай уншина уу. Саналын тоогоо илүү эсвэл буруу өгсөн тохиолдолд таны саналын хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу. **Жишээ нь:** Хувьцаа эзэмшигч та “Улаансан” ХК-ийн 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол “Улаансан” ХК-ийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн хараат бус гишүүн байхаар тогтоосон. Таны эзэмшиж буй 100 ширхэг хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд 900 ($100 \cdot 9 = 1000$) болох ба үүнээс 500 саналын эрхээрээ ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 400 саналын эрхээрээ хараат бус гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болохыг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч та саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2024 оны сарын..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

ХАВСРАЛТ 3. ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 21-ний өдөр

№

Улаанбаатар хот

ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны Санхүүгийн болон Үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Компанийн гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ө.АШХҮҮ

**“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 21-ний өдөр

№

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14 дэх хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Улаансан” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ө.АШХҮҮ

**“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 21-ний өдөр

№

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн эрхлэх үндсэн үйл ажиллагааны чиглэлийг дараах үйл ажиллагаа эрхлэхээр болгон өөрчилсүгэй:
 1. Менежментийн зөвлөгөө өгөх
2. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан өөрчлөлтийг оруулж, Дүрмээс дараах үйл ажиллагааны чиглэлийг хассугай:
 - Газар тариалан <Буудай тариалах>
 - Таван хошуу мал аж ахуй
 - Гахайн аж ахуй
 - Гадаад, дотоод худалдаа үйлчилгээ
 - Малын хадлан тэжээл бэлтгэх
 - Гурил хийх
 - Техник засвар үйлчилгээ
3. Компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр шинэчлэн баталсугай.
4. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд орсон өөрчлөлтийг төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ө.АШХҮҮ

**“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 21-ний өдөр

№

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, “Улаансан” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажилд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ө.АШХҮҮ

**“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 21-ний өдөр

№

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Улаансан” ХК (“**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгож чөлөөлсүгэй. Үүнд:

Ердийн гишүүд:

1. Ч.Ганхуяг
2. Г.Уянга
3. Ч.Даваасамбуу
4. Х.Билгүүн
5. С.Нямгэрэл
6. Б.Золбоо

Хараат бус гишүүд:

1. А.Азбаяр
2. Г.Зол-Эрдэнэ
3. Ц.Батбаяр

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ө.АШХҮҮ

**“УЛААНСАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 21-ний өдөр

№

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, “Улаансан” ХК (“**Компани**” гэх)-ийн Дүрмийн дугаар зүйлийн 8.4.8 дэх хэсэг болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгон, томилсугай: Үүнд:

Ердийн гишүүд:

1.
2.
3.
4.
5.
6.

Хараат бус гишүүд:

1.
2.
3.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ө.АШХҮҮ